



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны ээлжит 09 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2022 оны ээлжит 09 дүгээр хуралдааныг 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 09 дүгээр хуралдаанд "Харилцаа холбооны зохицуулах хорооны дунд хугацааны стратеги, төлөвлөгөө: 2022-2025 он" баримт бичгийн төслийн тухай; "Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 62 тоот тогтоол); "Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны эхний хагас жилийн үндсэн үзүүлэлтүүд"-ийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ олгох, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох) асуудлыг боловсруулан хэлэлцүүлж, нийт 6 тогтоолыг батлав.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороо нь дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө 5 жил тутамд баталж, ажилладаг бөгөөд "Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги, 2019-2024" баримт бичгийг тус хорооны хуралдааны 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Тус хорооны даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/08 тушаалаар Дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Ажлын хэсгээс 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Харилцаа холбооны тухай хууль болон салбарын бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон, 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хууль шинээр батлагдсан, Цахим хөгжлийн багц хуулиуд (*Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль*, *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль*, *Цахим гарын үсгийн тухай хууль*, *Кибер аюулгүй байдлын тухай хууль*) шинээр болон шинэчлэгдэн батлагдсан зэрэг хууль эрхзүйн орчны өөрчлөлт, Цахим хөгжил харилцаа холбооны яам байгуулагдаж салбарын институцид томоохон өөрчлөлт орсон болно. Цар тахлын улмаас бизнесүүдэд болон зохицуулалтын чиг хандлагад орж байгаа өөрчлөлтүүд зэрэг гадаад нөхцөл байдлын улмаас тус хороо нь дунд хугацааны стратегийн баримт бичгээ зайлшгүй шинэчлэх шаардлага гарч ирсэн. Байгууллага гол нөөцүүдээ үр ашигтай удирдах зорилгоор төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээний системийг сайжруулах зөвлөх үйлчилгээг KPI Institute (Австралид төвтэй, олон улсын зөвлөх) мэргэжлийн байгууллагаас авч, ажлын хэсгээс "Харилцаа холбооны зохицуулах хорооны дунд хугацааны стратеги, төлөвлөгөө: 2022-2025 он" баримт бичгийн төсөл боловсруулав. Тус хорооны хуралдаанд ажлын хэсгээс "Харилцаа холбооны зохицуулах хорооны дунд хугацааны стратеги, төлөвлөгөө: 2022-2025 он" баримт бичгийн танилцуулга, үйл ажиллагааны хэрэгжүүлэх төлөвлөгөө, тогтоолын төслийг хэлэлцүүлсэн бөгөөд Хорооны дүрмийн 2.1.2 дах заалтыг үндэслэн 2022 оны 09 дүгээр 21-ний өдрийн 42 тоот "Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022-2025 оны үйл ажиллагааны стратеги" батлах тухай" тогтоолыг хавсралтын хамт батлав. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2019 оны 01 тоот тогтоолыг хүчингүй

болгов. Уг баримт бичгээр батлагдсан стратеги, төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ, заалтуудыг зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги болон байгууллагын жилийн төлөвлөгөө (Үйл ажиллагааны болон санхүүгийн)-ны уялдааг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болголоо.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн **26.6**-д “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын үнэ тарифын үндэслэл, үндсэн багцад тавигдах шаардлагыг Зохицуулах хорооноос баталсан журмаар хянаж, зохицуулна.”, 30 дугаар зүйлийн **30.1.7.в**-д буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх үүрэг хэсэгт “олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-ыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих гэж, мөн хуулийн 20-р зүйлийн **20.5.3**¹ -д үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогоос өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах тухай заасан. Эдгээр хуулийн үндэслэлийг баримтлан “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багц”-ын журмын төслийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7-д заасан эрх үүргийнхээ хүрээнд 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 62 дугаар тогтоолоор “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-ыг баталсан. Өнгөрсөн хугацаанд журмыг хэрэгжүүлж, журмын хэрэгжилтэд үнэлгээ хийсний үндсэн дээр зарим заалтуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулах шаардлагатай болсон ба ӨНЗГ-аас журмын 6 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар “Захиргааны ерөнхий хууль”-ын 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох аргачлалын дагуу оролцогч талууд, ТББ, байгууллагатай хийсэн хэлэлцүүлэг, уулзалтын үр дүн, саналыг тусган боловсруулжээ. Хорооны 2022 оны ээлжит 09 дүгээр хуралдаанд “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулга, тогтоолын төсөл, баримт бичгийн төсөл, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, саналын товчоо, нөлөөллийн шинжилгээг тус тус хэлэлцээд, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7.в дэх заалтыг үндэслэн 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 43 тоот тогтоолоор хорооны 2020 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/1349 албан тоотой хүргүүлсэн ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4903 дугаарын бүртгэлтэй 2020 оны 62 тоот тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан 2022 оны 43 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ олгох, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

¹ 20.5.3 өргөн нэвтрүүлгийн радио, телевизүүд нь энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 09 дүгээр 21-ний өдрийн 44 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 09 дүгээр 21-ний өдрийн 45 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 09 дүгээр 21-ний өдрийн 46 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 09 дүгээр 21-ний өдрийн 47 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-10-04